



НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 22


Улаанбаатар хот


┌ Дүрэмд өөрчлөлт оруулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XVII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 51 дүгээр тогтоолын хавсралт “Хан-Уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ын дүрэм”-ийн 3 дахь хэсэгт хавсралтаар нэмэлт оруулсугай.

2. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн хяналт тавьж, хэрэгжүүлэхийг, дүүргийн Засаг дарга (Ж.Алдаржавхлан)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.БАТСАЙХАН



Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны 09 дүгээр сарын 21-ний
өдрийн 22 тогтоолын хавсралт

“Хан-Уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-н дүрэм”

3.3. Авто зам, замын байгууламжийн чиглэлээр мэргэжлийн байгууллага, аж ахуй нэгж, иргэдтэй хамтран ажиллах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих

3.4. Ашиглалт, засвар үйлчилгээ, хөрөнгө оруулалтын ажилд шаардагдах түүхий эд материал, тоног төхөөрөмжийг гадаад, дотоодын зах зээлээс нийлүүлэх, худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх